

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ/

2017 оны 6 дугаар сарын 30

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2017 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар гарсан шийдвэр заалтыг хяналтанд авч, эдгээрийн 2017 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, заалтыг 2017 оны 6 сарын 5-ны өдрийн байдлаар тасалбар болгон Засгийн газрын 2017 оны 89-р тогтоолоор батлагдсан журмын 6-р хавсралтын дагуу салбар тус бүрээр Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэсэн таван ангиллаар хэрэгжилтийг гаргуулав.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

2017 оны эхний хагас жилийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 135 шийдвэрийн 188 заалтыг дээр дурдсан агуулгаар ангилж хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилт **83.0** хувийн биелэлттэй байна.

Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 8 шийдвэрийн 10 заалтын хэрэгжилт 81.7%, газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 31 шийдвэрийн 34 заалтын хэрэгжилт 82.0%, уул уурхайн бодлогын асуудлын 32 шийдвэрийн 52 заалтын хэрэгжилт 73.0%, хүнд үйлдвэрийн бодлогын асуудлын 32 шийдвэрийн 46 заалтын хэрэгжилт 83.0%, нийтлэг асуудлын 34 шийдвэрийн 49 заалтын хэрэгжилт 87.8 хувийн тус тус биелэлттэй байна.

Дээрх шийдвэрүүдийн 74 заалт буюу 38.7% бүрэн биелсэн, 72 заалт буюу 37.7% хэрэгжилтийн шатанд буюу 30-70 хувийн биелэлттэй байна. Үүнд 58 заалт буюу 30.4% нь 70 хувийн биелэлттэй, 14 заалт буюу 7.3% нь 30 хувийн биелэлттэй, хэрэгжилтийн хугацаа болоогүй 3 шийдвэр, хэрэгжилтэд үнэлгээ өгөөгүй 43 заалт байна.

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**
/2017 оны эхний хагас жил/

Хүснэгт-1

| | | Бүгд | Монгол улсын хууль | УИХ-ын тогтоол | УИХ-ын байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | Засгийн газрын тогтоол | Засгийн газрын хуралдааны | Ерөнхий сайдын захирамж | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл |
|-----------------------|------------------------|------|--------------------|----------------|--------------------------------|-----------------------|------------------------|---------------------------|-------------------------|---|
| Хяналтанд авсан | Тогтоол шийдвэрийн тоо | 135 | 10 | 11 | 13 | 3 | 48 | 35 | 5 | 10 |
| | Зүйл, заалтын тоо | 189 | 14 | 16 | 35 | 6 | 57 | 39 | 6 | 16 |
| Үүнээс Үүний дотор | Биелсэн | 74 | 4 | 5 | 12 | 4 | 29 | 15 | 3 | 2 |
| | Хэрэгжих шатанд | 72 | 7 | 9 | 15 | - | 13 | 14 | 2 | 12 |
| | 70.0% | 58 | 7 | 8 | 13 | - | 8 | 10 | 1 | 11 |
| | 30.0% | 14 | - | 1 | 2 | - | 5 | 4 | 1 | 1 |
| | Хэрэгжээгүй | - | - | - | - | - | - | - | - | - |
| | Дүгнэгдээгүй | 43 | 3 | - | 8 | 2 | 15 | 9 | 1 | 2 |
| Хугацаа болоогүй | 3 | - | 2 | - | - | - | 1 | - | - | |

Дөрөв. Дүгнэлт.

1. Яамны холбогдох газруудаас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй ажлууд хийж байгаа боловч биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлэх, ажлын гол үр дүнг товч тодорхой, баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.

2. Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх шийдвэрийн биелэлт гаргахад тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар толгойлон хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй байдал давтагдсаар байна.

3. ЗГХЭГ-ын зүгээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан шийдвэрүүд бүгд дугааргүй, зарим тогтоол шийдвэрийн утга тавигдаагүй, www.legalinfo.mn эрх зүйн мэдээллийн нэгдсэн сиситемээс хайхад эдгээр шийдвэрүүдийг байршуулаагүй байгаа нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах болон үнэлгээ хийхэд хүндрэлтэй байв.

Яамны зүгээс тодорхой хийгдсэн ажлын биелэлтгүй, эсвэл тус яамны эрхлэх асуудалд хамааралгүй, шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөн шалтгаанаар үргэлжлэн хэрэгжээгүй, дээд шатны байгууллагаас ажлыг зогсоосон зэрэг 40 заалт байна. 3 заалтын хэрэгжих хугацаа болоогүй тул үнэлгээ өгөөгүй болно. Үүнд:

Хүснэгт-2

| Д/д | ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО | | | | | | |
|----------------------------|--|------------|---|--|--|--|--|
| Засгийн газрын тогтоол | | | | | | | |
| 1 | Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах эрх олгох тухай №431 | 2015-11-02 | хуваах гэрээг цуцлан газрын тосны тухай хууль тогтоомж болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгасугай. | | | | |
| ГУРАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО | | | | | | | |
| МУ-ын хууль | | | | | | | |

| | | | |
|---|---|---|-------|
| 2 | Цөмийн 2009-07-16 Засгийн газар батална. | энергийн 33.4 Цөмийн материалыг бүртгэх, хянах журмыг | тухай |
| Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | |
| 3 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2015-02-18 1.3. Тогтоолын биелэлтийг 2015 оны хаврын чуулганы хугацаанд багтааж танилцуулах | | |
| 4 | Шалгалтын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2015-04-08 №10 1.2 "Эрдэнэс таван толгой" хувьцаат компаний Хөгжлийн банкнаас авсан зээлийг хувьцаанд хөрвүүлэх асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах | | |
| 5 | Чиглэл 2015-05-29 | өгөх | тухай |
| 3 Оюу толгой ордыг ашиглахтай холбогдуулан хувь нийлүүлэгчдийн хооронд нягтлан бодох бүртгэлийн стандартын зөрүү, уул уурхайн салбарт хуримтлуулсан туршлагын ялгаа зэргээс хамааран үл ойлголцол, хууль тогтоомжийн зөрүү зэргийг арилгах, олон улсын болон Монгол Улсын холбогдох стандарт, дүрэм журмыг нэг мөр болгож цэгцлэх, олон нийтийг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах | | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | |
| 6 | Үйлдвэржилтийг эрчимжүүлэх талаар 2015-01-29 | Засгийн газарт чиглэл өгөх тухай | тухай |
| 9/ 9/Эрдэнэс баялгийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах уялдаа холбоо бүхий "нэг цонхны бодлоготой" болох; | | | |
| Засгийн газрын тогтоол | | | |
| 7 | Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм, 2014-09-18 | бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | тухай |
| 2 Гаалийн тарифтай холбоотой бодлогын асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийн өмнө Гаалийн тарифын зөвлөлөөр хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | | | |
| 8 | Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай 2014-08-20 | тухай | тухай |
| 1.6 Хөрөнгө оруулагч нь Баруун болон Зүүн Цанхийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайд нүүрс олборлох, тэдгээр талбайд нэмэлт хайгуул хийж нөөцийг нэмэгдүүлэх; | | | |
| 9 | Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай 2014-08-20 | тухай | тухай |
| 1.д Хөрөнгө оруулагч нь улсын төсөвт төлөх татвар, хураамж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хариуцахаас гадна борлуулалтын орлогын тодорхой хувийг Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний төлбөрт төлөх, шаардлагатай тохиолдолд нэмж төлөх борлуулалтын орлогын тодорхой хэсгийг урьдчилан төлөхөөр хэлэлцэх; | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | |
| 10 | 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр 53 дугаар тэмдэглэл 2015-09-28 | ХҮI. 5. Тавантолгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагч талтай байгуулах гэрээний төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн хэлэлцээний явц, үр дүнгийн талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулсантай холбогдуулан хөрөнгө оруулагч талаас тавьж байгаа санал, нөхцөлийг тухай бүр танилцуулан уг хэлэлцээг ойрын хугацаанд дуусгах чиглэлээр ажиллахыг Ажлын хэсэг (Б.Бямбасайхан)-т даалгав. | |
| 11 | 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 35 дугаар тэмдэглэл 2016-06-20 | IX. 3. "Багануур" ХК-ийн бэлтгэгдсэн мэргэжлийн ажиллах хүчин, нөөц бололцоонд тулгуурлан үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, хуримтлагдсан өр авлагыг бууруулах зорилгоор Тавантолгойн нүүрсний ордын "Баруун цанх"-ийн хэсэгт хөрс хуулах, нүүрс олборлох ашиглалт явуулах талаар дээрх компанийн удирдлагаас тавьсан хүсэлтийг хэрэгжүүлэх боломжийг судлан саналаа танилцуулахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан нарт даалгав. | |
| 12 | 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 35 дугаар тэмдэглэл 2016-06-20 | VII. Монгол Улсын Засгийн газар болон "Тавантолгой цахилгаан станц" ХХК-ийн хооронд байгуулах "Тавантолгой цахилгаан станц төсөл"-ийн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцээд асуудлыг зарчмын хувьд дэмжиж, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу Эрчим хүчний яам, Гадаад хэргийн яам болон бусад яамдын саналыг судлан | |

| | |
|---------------------------------------|--|
| | тусгаж, хууль тогтоомжид нийцүүлсний үндсэн дээр Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурахыг Монгол Улсын сайд М.Энхсайханд даалгав. |
| ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО | |
| УИХ-ын тогтоол | |
| 13 | Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай 2015-06-19 2.4 4/дунд, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, бүтээмж болон өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангиллын дагуу гаргасан албан ёсны статистик үзүүлэлтэд үндэслэн бодлогын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, шаардлагатай арга хэмжээг авах. |
| Ерөнхийлөгчийн зарлиг | |
| 14 | Үйлдвэржилтийг эрчимжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх тухай 2015-01-29 3/ 3/Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, импортыг орлосон, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах бодлогыг хэрэгжүүлэх, гадаад зах зээлд өрсөлдөхүйц Монгол Улсын “Нэрийн бүтээгдэхүүн”-ийг олшруулах; |
| Засгийн газрын тогтоол | |
| 15 | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай 2015-05-18 2 Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Хөрөнгө оруулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатарт, хэлэлцээ хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад тус тус даалгасугай. |
| 16 | Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай 2015-06-15 2 Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулан төр, хувийн хэвшлийн оролцооны хувь хэмжээг тогтоож, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг сонгон хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээ авахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийлгэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхоролд тус тус даалгасугай. |
| 17 | Жагсаалт батлах тухай 2015-08-17 № 336 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авсан нийт бараа, бүтээгдэхүүний худалдан авалтын мэдээг улсын хэмжээнд нэгтгэн жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт тайлагнаж байхыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад үүрэг болгосугай. |
| 18 | 2 Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэрийн сайд, Сангийн сайд нарт үүрэг болгосугай. |
| 19 | Тусгай зөвшөөрөл олгох тухай 2015-11-02 2 Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Гаалийн ерөнхий газрын дарга О.Ганбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ш.Раднаасэд нарт үүрэг болгосугай. /янжуур тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл/ |
| 20 | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай 2016-01-04 2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдүүдтэй хэлэлцээ хийхийг Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, зохих журмын дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат нарт тус тус даалгасугай. |
| 21 | Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барихтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016-02-01 1 Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд жилд 2.3 сая тонн хүртэл газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барих зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгасугай: 1/ төсөл хэрэгжүүлэх үндэсний компанийн оролцоотой консорциумыг сонгох уралдаант шалгаруулалтыг 2016 оны I улиралд багтаан зохион байгуулах; 2/ уралдаант шалгаруулалтад шалгарсан хөрөнгө оруулагчтай улсын захиалгаар хийсэн газрын тос боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн төлбөрийг |

| | |
|-----------------------------------|--|
| | төлөх нөхцөлтэйгээр үйлдвэр барьж ашиглалтад оруулах, ажиллуулах талаар хэлэлцээ хийж, гэрээ байгуулах; 3/ газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барих барилгын ажлыг энэ оны II улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээ авах. |
| 22 | Газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барихтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016-02-01 3 Газрын тос дамжуулах хоолой барих төслийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдүүдтэй хэлэлцээ хийхийг Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохих журмын дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат нарт тус тус даалгасугай. |
| 23 | 4 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан үйлдвэрийг барих талбайн хэмжээ, газрын тос дамжуулах хоолой барих трассыг тогтоож, шаардагдах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг боловсруулж зохих журмын дагуу Засгийн газарт оруулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай. |
| 24 | Зөвшөөрөл олгох тухай 2016-02-04 2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан зээлийг эргэн төлөх ажлыг Засгийн газрын 2016 оны 75 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгасугай. |
| 25 | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай 2016-02-08 2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийхийг Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохих журмын дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат нарт тус тус даалгасугай. |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | |
| 26 | 2015 оны 02 дугаар сарын 12-ний өдөр 10 дүгээр тэмдэглэл 2015-02-12 II. 2. Эдийн засгийн түншлэлийн тухай Энэхүү хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон баталсны дараа Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат нарт даалгав. |
| 27 | 2016 оны 03 дугаар сарын 28-ний өдөр 18 дугаар тэмдэглэл 2016-03-28 I Дотоодын үйлдвэрлэлийг гадаад худалдаанаас учирч болох хохирлоос хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн дэмжээд үзэл баримтлалыг Хууль зүйн сайдтай хамтран баталж, хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан хуулийн төслийн нэрийг оновчтой болгох зэрэг саналыг тусган хуулийн төслийг боловсруулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав. |
| 28 | 2016 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр 20 дугаар тэмдэглэл 2016-04-04 ХҮIII. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль зүйн сайдтай хамтран боловсруулж, зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав. |
| 29 | 2016 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2016-04-18 “ХҮ. “Хөшигийн хөндий чөлөөт бүс байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг хэлэлцээд үзэл баримтлалыг батлахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Хууль зүйн сайд Д.Дорлигжав нарт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар зохих журмын дагуу хэлэлцүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад тус тус даалгав. |
| 30 | 2016 оны 06 дугаар сарын 13-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2016-06-13 ҮI. “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай” Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд дахин судалж үзсэний үндсэн дээр саналаа Засгийн газарт оруулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгав. |
| 31 | 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2016-11-30 XII.2 Үйлдвэржилтийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг яаралтай боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн нарт даалгав. |

| ТАВ. НИЙТЛЭГ АСУУДАЛ | |
|---|--|
| МУ-ын хууль | |
| 32 | <p>МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2009-07-16</p> <p>7. “6.Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах, ашиглах, цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар нөхөн сэргээх, цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээнд хамаарахгүй.</p> <p>7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.”</p> |
| 33 | <p>Хүний хөгжил сангийн тухай 2009-11-18</p> <p>13.2 Энэ хуулийн 13.1-д заасан сонгон шалгаруулалтын журам болон менежментийн гэрээг Засгийн газар батална./13.1.Энэ хуулийн 8.2-т заасан хуулийн этгээдийн чиг үүргийг дараахь шаардлагыг хангасан олон улсын санхүүгийн байгууллагад сонгон шалгаруулалтын үндсэн дээр менежментийн гэрээгээр хэсэгчлэн шилжүүлж болно: 8.2.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлнэ./</p> |
| УИХ-ын тогтоол | |
| 34 | <p>Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай 2016-02-05 № 19</p> <p>2/ Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах;</p> |
| Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | |
| 35 | <p>Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016-01-12</p> <p>Нэг. Уул уурхай, байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд хуулийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/- т чиглэл болгосугай.</p> <p>1/Уул уурхайгаас ангид байх газруудыг тодорхойлон хамгаалах, экологийн бүс нутгийн үнэлгээ хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p> |
| 36 | <p>Нэг.2/ Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө тооцох хэлбэр, хэмжээг шинэчлэх, эрсдлийг бүрэн даахуйц болгох,</p> |
| 37 | <p>Нэг.3/ Ашигт малтмалыг олборлох, боловсруулахад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үндэсний стандартыг бий болгож мөрдүүлэх, уурхайн хаалтыг европын холбоо болон өндөр хөгжилтэй орнуудын жишигт нийцүүлэх, хариуцлагатай уул уурхайн зарчмыг бүх уул уурхайн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, үнэлэх арга, аргачлалыг батлан мөрдүүлэх;</p> |
| 38 | <p>Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016-12-21</p> <p>1 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 17.2.9, 54.11, 57.2, Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.9, 39.3, 39.7 дахь хэсгийн хэрэгжилтийг хангаж, хяналтыг сайжруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах, холбогдох журам, стандартыг гаргах</p> |
| 39 | <p>11 Тогтоолын биелэлтийн явцыг 2017 оны эхний хагас жилд багтаан тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, Байгаль орчин, аялал жуулчлалын яам /Д.Оюунхорол/, Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам /Ц.Дашдорж/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Н.Цагаанхүү/-т тус тус даалгасугай</p> |
| ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | |
| 40 | <p>Байгалийн ургамал, амьтныг хамгаалах талаар авах зарим арга хэмжээний тухай 2013-01-08</p> <p>2. Говь, хээрийн бүсийн түлшний асуудлыг цогцоор шийдэх бодлогын хүрээнд мод, сөөг, сөөгөнцөр ургамал түлшинд хэрэглэхийг хязгаарлах зорилгоор түүхий нүүрсийг гүн боловсруулж цэвэр түлшээр төв, орон нутгийг хэрэгцээг хангах ажлыг эрчимжүүлэх;</p> |
| Засгийн газрын тогтоол | |

| | |
|--|--|
| 41 | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2015-07-20 2 Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай. |
| Ерөнхий сайдын захирамж | |
| 42 | Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай 2014-05-16 №61 2 Нээлттэй засгийн түншлэлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нарийн бичгийн даргад даалгасугай. |
| Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | |
| 43 | 2016 оны 10 дүгээр сарын 26-ны өдөр 52 дугаар тэмдэглэл 2016-10-26 XIII.1. 2. хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан асуудлыг судалж гаргасан дүгнэлтэд тусгагдсан асуудлыг шийдвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа хууль бус дарамт, шаардлагуудыг арилгаж, хүчингүй болгох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт. |

Тав. Зөвлөмж.

Цаашид холбогдох нэгжүүдийн мэргэжилтнүүд баримт бичиг боловсруулах ур чадвараа сайжруулж, ирүүлж буй тайлангийн чанарт анхаарах, мэргэжилтний боловсруулсан тайлан, мэдээллийг харьяалах нэгжийн дарга нар сайтар хянаж, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мөн ХШҮДАГ-тай нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.